

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ Б.БИЛЭГТ



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГААС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2016 оны 02 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт				Хариуцах эзэн	Хүрэх үр дүн	Оноо
			Хүн хүч	Хөрөнгө санхүү	Хугацаа	Гүйцэтгэлийн үзүүлэлт			
<b>НЭГ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ САНАЛ, САНААЧЛАГА</b>									
1	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх	1.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга авлигыг үл тэвчих, ёс зүйтэй байх, шударга ёсыг эрхэмлэн ажиллах талаар үүрэг чиглэл гаргах.	Хүн/өдөр		1-р улиралд	-Нийт бие бүрэлдэхүүнд хүргэсэн байх.	ШШГЕГ-ын дарга, Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасаг	Удирдлагын манлайлал дээшилж иргэдийн дунд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах бие бүрэлдэхүүнд итгэх итгэл нэмэгдэнэ.	
		1.2 Авлигын эсрэг арга хэмжээнд зориулсан санхүүжилтийг шийдвэрлүүлэх, 2017 оны төсөвт тусгуулах	Хүн/өдөр		Жилд	-Авлигын эсрэг арга хэмжээнд зориулсан хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн байдал.	Санхүү, Үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгж		
2	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	2.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Авлигаас урьдчилан сэргийлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Хүн/өдөр		2 дугаар сарын 15-ны дотор	-Авлигаас эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлсэн байх	Хяналт шалгалтын хэлтэс		
		2.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Авлигаас урьдчилан сэргийлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тооцож, тайланг нотлох баримтын хамт Авлигатай тэмцэх газар хүргүүлэх	Хүн/өдөр		11 дүгээр сарын 15-ны дотор	-Хэрэгжилтийн тайланг нотломжийн хамт Авлигатай тэмцэх газар хүргүүлсэн байх	Хяналт шалгалтын хэлтэс		
		2.3 Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын санал гаргах	Хүн/өдөр		Жилдээ	-Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө бүрэн хангагдаж үр дүн сайжирна.	Хяналт шалгалтын хэлтэс		
3	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг	3.1 Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар сургалт зохион байгуулах	Хүн/өдөр		1 дүгээр улиралд	-Нийт албан хаагчид хамрагдсан байх	Хяналт шалгалтын хэлтэс		

*Handwritten signature and initials:*  
 Б/с М.Баянзүрэг  
 Удирдлагын  
 ОК



	нэмэгдүүлэх	3.2 Ажлын байрны шаардлагыг бүрэн ханган ажиллаж байгаа алба хаагчдыг тогтвортой ажиллах, дэвших боломжоор хангаж, төрийн албаны чадахуйц /мерит/ тогтолцоог төлөвшүүлэх	Хүн/өдөр		Хагас жил, 11-р сарын 01-ний дотор	-Алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ	Хүний нөөцийн тасаг		
<b>ХОЁР. ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ</b>									
4	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах	4.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авлигын талаар гомдол, мэдээлэл хүлээн авах утас, саналын хайрцаг ажиллуулах	Хүн/өдөр		Жилд	-Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/	Хяналт шалгалтын хэлтэс, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгж	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирна.	
		4.2 "Та авлигагүй бүсэд нэвтэрлээ" мэдээллийн самбарыг тогтмолжуулж, иргэдэд авлигын талаар мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлэх				Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгж			
	4.3 Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх	Хүн/өдөр	Тухай бүр	- Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар иргэд, байгууллага болон албан хаагчид мэдээлэлтэй болсон байх - Сурталчилгааны материал тараагдсан байх	Хяналт шалгалтын хэлтэс,				
	4.4 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм, зааврыг алба хаагчдад танилцуулах	Хүн/өдөр	Жилд	-Гарын авлага товхимол хэвлэгдэж хүргэгдсэн байх.	Хяналт шалгалтын хэлтэс, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгж				
	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн	5.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх журмын төслүүдийг алба хаагчдад танилцуулах, хэлэлцүүлэх, санал солилцох.	Хүн/өдөр		Байнга	-Дүрмийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, нэгжид хүргүүлсэн байх. -Хэрэгжилтийг тухай бүр тооцож ажилласан байх	Хууль, олон нийттэй харилцах тасаг	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	



5	төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	5.2. Нийтээр дагаж мөрдөх төсөлд санал авах	Багаар		Тухай бүр	-Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ шинээр боловсруулан шийдвэрийн төслийг олон нийтэд байршуулан санал авсан байдал.	Хууль, олон нийттэй харилцах тасаг		
5		5.3. Шинээр боловсруулагдаж батлагдсан бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг цахим хуудсанд байршуулан олон нийтэд танилцуулах	Хүн/өдөр		Тухай бүр	-Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байдал	Хууль, олон нийттэй харилцах тасаг		
6	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	6.1. Хяналт шалгалтын хэлтсээс төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг хийж, шалгалтын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах.	Багаар		Тухай бүр	-Шалгалт хийсэн байх -Хийсэн ажил, шалгалтын шийдвэрийн талаар нийтэд мэдээлсэн байх /нууцаас бусад асуудлыг/	Хяналт шалгалтын хэлтэс,	Дотоод хяналт шалгалт сайжирч, байгууллагын үйл ажиллагаа шуурхай болж, алба хаагчдын шударга байдал дээшилнэ.	
		6.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, албадуудад санхүүгийн шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.	Хүн/өдөр		Тухай бүр	-Шалгалт хийгдсэн байх -Дутагдлыг засуулсан байх	Стратеги төлөвлөлт дүн шинжилгээний төв		
7	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	7.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шийдвэр гүйцэтгэгчийн эрх олгох шалгалт авахад бүрдүүлэх материал, хаана, хэнд, хэрхэн хандах зэргийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр цахим хуудсанд байршуулах	Багаар		Тухай бүр	-Тухайн байгууллагаас олгож буй өртэй этгээдийн лавлагаа, шийдвэр гүйцэтгэгчийн эрх олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмын нээлттэй байдал	Шийдвэр гүйцэтгэх газар	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	



8	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	8.1 Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг баталж, үр дүнг гэрээг байгуулах	Хүн/өдөр		Тухай бүр	-Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт батлагдсан, үр дүнгийн гэрээ байгуулагдсан байх.	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасаг	Албан хаагчдын ажил үүргийн хуваарь тодорхой болж ажлын бүтээмж сайжирна.	
		8.2 Албан хаагчдын ажил, үр дүнг Шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны журмыг баримтлан үнэлж, дүгнэх.	Хүн/өдөр		Жилд	-Шалгуур үзүүлэлтийг баримтлан ажил, үр дүнгийн гэрээг дүгнэсэн байх.	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасаг, Хорих анги, Шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгж		
		8.3 Алба хаагч нэг бүрийн ажил үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах			2-р улиралд	-Цахим хуудсанд нээлттэй болсон байх --Албан хаагчдын ажил үүргийн хуваарь нийтэд ил тод болно.	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасаг,		
9	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	9.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-уудыг шинэчлэн томируулж, ажлын байрны тодорхойлолтыг батлуулах.	Хүн/өдөр		Жилд	-Эрх бүхий албан тушаалтныг томилсон байдал -Гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байдал -Хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал, баталгаа/ -Эрх бүхий албан тушаалтны ажлын үр дүнгийн байдал	Хяналт шалгалтын хэлтэс, Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар, Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасаг	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа сайжирна.	
		9.2 Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгжийн эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-уудад сургалт зохион байгуулах.	Багаар		Жилд	-Байгууллагын хэмжээнд сургалт зохион байгуулсан байх -Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал	Хяналт шалгалтын хэлтэс		



10	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах/	10.1. Иргэдээс гаргасан, ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авч бүртгэн мэдээллийн санд оруулж шийдвэрлэлтийг удирдлагын зүгээс байнга хянаж, хүний зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хангаж ажиллах.	Багаар		Жилдээ	-Гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэх -Мэдээллийн санд оруулсан байх -Удирдлагын зүгээс байнга хянаж байх -иргэдийн зөрчигдсөн эрх хангагдсан байх	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасаг, Хорих анги, Шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгж	Авлигын эсрэг, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэр лэх тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	
		10.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад биеэр хандаж ирсэн иргэнийг угтах "Нэг цонхны үйлчилгээ"-г тогтмолжуулж, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, байгууллагын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх	Хүн/өдөр		Тухай бүр	-төрийн үйлчилгээ чирэгдэлгүй шуурхай байх	Захиргааны Удирдлагын газар, Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба салбар нэгж		
		10.3. Алба хаагчийн хууль бус үйлдэл, авлига, хүнд суртлын талаарх тусгай дугаарын утас болон бичгээр ирсэн гомдол, мэдээллийн мөрөөр шалгалт хийж, шийдвэрлэж байх.	Хүн/өдөр		Тухай бүр	-Гомдол, мэдээллийн мөрөөр тодорхой ажил зохиосон байх -Нууц задруулсан тохиолдолд хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжсэн байх	Хяналт шалгалтын хэлтэс,		
		10.4.Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар мэдээллэх	Хүн/өдөр		Тухай бүр	-Иргэдэд мэдээлэл түргэн шуурхай хүрсэн байх	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасаг		
		10.5 Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, харилцах утас, иргэнийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах	Хүн/өдөр		1-р улиралд	-Мэдээлэл байршуулсан байх	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасаг Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба салбар нэгж		
11	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	11.1. Алба хаагчдаас авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон, зуучилсан талаарх мэдээллийг тухай бүр харилцан солилцож, хамтран ажиллаж, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллах	Хүн/өдөр		Тухай бүр	-Мэдээллийг тухай бүр харилцан солилцож хамтран ажилласан байх -Мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлүүлсэн байх	Хяналт шалгалтын хэлтэс, Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгж		



		11.2. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгжийн ЭБАТ-ууд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, харьяа орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран алба хаагчдад танхимийн сургалтыг зохион явуулах	Хүн/өдөр		Жилдээ	-Үйлчилгээний байр хэрэгжүүлсэн байх -Сургалтыг зохион байгуулсан байх	Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар, нэгж		
		11.3 Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах			2-р улиралд	-Жагсаалт гаргасан байх	Хяналт шалгалтын хэлтэс	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирна.	
		11.4. Удирдах албан хаагчдын авлигын хандлагын талаар нийт бүрэлдэхүүнээс болон орон нутгийн хууль хяналтын байгууллага, иргэдээс санал асуулга авч, тандалт хийж, дүгнэлт гаргаж, дүнг удирдлагад танилцуулсан байх	Багаар		Жилдээ	-Нэргүй санал асуулга авах -Санал асуулгын дүнд тулгуурлан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх	Хяналт шалгалтын хэлтэс		
12	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх	12.1. Алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	Хүн/өдөр		Тухай бүр	-Хөрөнгө орлогын мэдүүлгийг хүргүүлсэн байх	Хяналт шалгалтын хэлтэс	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хангагдана.	
		12.2. Алба хаагчдын мэдүүлсэн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.	Хүн/өдөр		Тухай бүр	Зөрчил арилсан байх	Хяналт шалгалтын хэлтэс		
		12.3. Шинээр томилогдсон болон их хэмжээний өөрчлөлт орсон алба хаагчдаас тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч цахим санд оруулах, түүнд хяналт тавих.	Хүн/өдөр		Тухай бүр	-Мэдээлэл цахимд бүртгэгдсэн байх	Хяналт шалгалтын хэлтэс		
13	Төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	13.1 Төрийн бус байгууллагатай хамтран алба хаагчдад сургалт зохион байгуулах.	Хүн/өдөр		11-р сарын 01-ний дотор	-Тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байх	Албаны сургалт, дадлагын хэлтэс		
		13.2 Ялтныг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, хүмүүжлийн ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байх.	Хүн/өдөр		Жилдээ	-Тодорхой үйл ажиллагаа хэрэгжиж үр дүнд хүрсэн байх	Тогтоол гүйцэтгэх газар		
14	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг	14.1 Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгах	Хүн/өдөр		2-р улиралд	-Ёс зүйн дүрэм хэрэгжсэн байх	Хяналт шалгалтын хэлтэс Хууль, олон нийттэй харилцах тасаг	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийн	
		14.2 Ёс зүйн дүрмийг батлуулан, нийт албан хаагчдад танилцуулах							



	тогтоон мөрдүүлэх	14.3 Ёс зүйн дүрмийн хэрэгжүүлэлт д хяналт тавих					хэрэгжилт хангагдана.		
15	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	15.1 Давхар ажил эрхлэхтэй холбоотой судалгааг гаргаж, албан хаагчдад танилцуулах 15.2 Давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох	Хүн/өдөр		11-р сарын 01-ний дотор	-Судалгаа хийгдсэн байх - Зөвшөөрөл олгосон байх	Хүний нөөцийн тасаг	Хуулийн хэрэгжилт хангагдана.	
16	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах	16.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, харьяа нэгжийн удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалыг цахим хуудсанд байршуулах	Хүн/өдөр		Тухай бүр	-Мэдээлэл цахим хуудсанд байршуулсан байх	Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасаг Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба салбар нэгж	Удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдал хангагдана.	
		16.2 Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд тухай бүр байршуулах							
		16.3 Үйлчлүүлэгчээс авч буй төлбөрт үйлчилгээ, төлбөр болон хураамжийг цахим хуудсанд байршуулах			1-р улиралд	-Цахим хуудсанд байршуулсан байх	Мэдээлэл технологийн хэлтэс		
<b>ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ</b>									
17	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	17.1 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим хуудсанд хариуцан оруулах мэдээллийн бүтэц, товыг боловсруулж мөрдүүлэх	Багаар		Тухай бүр	-Цахим хуудасны мэдээллийн сангийн тасралтгүй үйл ажиллагаа хангагдсан байх.	Хууль, олон нийттэй харилцах тасаг	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	
18	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	18.1 Сул орон тооны зарыг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах	Хүн/өдөр		Тухай бүр	-Хүний нөөцийг ил тод байдлаар шударгаар бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг алба хаагч нар бүрэлдүүлсэн байх - Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө бүрэн хангагдаж үр дүн сайжирна.	Хүний нөөцийн тасаг		
		18.2 Ажилд авах, албан тушаал дэвшүүлэх, гадаад, дотоодод суралцуулах, шагнах, урамшуулах зэрэг сонгон шалгаруулах үйл ажиллагаа, журмуудыг нийтэд ил тод байлгах, оролцогч бүрийг ижил тэгш мэдээллээр хангаж шударгаар шийдвэрлэх.					Албаны сургалт, дадлагын хэлтэс, Хүний нөөцийн тасаг		



ДӨР ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАХ ЧИГЛЭЛЭЭР

19	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээллэх	19.1. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх	Хүн/өдөр		1 дүгээр сарын 15-ны дотор	-Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг цахим хуудсанд байршуулсан байх	Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангагдана.
		19.2 Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах	Хүн/өдөр		4 дүгээр сарын 01-ний дотор	-Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавьсан байх	Санхүү, Үйлдвэр, Хөрөнгө оруулалтын газар	
		19.3 Дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд байршуулах			8 дугаар сарын 15-ны дотор			
		19.4 Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулах			4 дүгээр сарын 01-ний дотор	Цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байх		
		19.5. Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар ШШГЕГ-ын даргын зөвлөлд мэдээлэл хийх, салбар зөвлөлд ирүүлэх. Цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.	Хүн/өдөр		Улирал бүр	-Төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэсэн байх. -Мэдээллийг ШШГЕГ-ын даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байх -Салбар зөвлөлд ирүүлсэн байх	Санхүү, Үйлдвэр, Хөрөнгө оруулалтын газар	
	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	20.1. Бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарыг цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх.	Багаар		Тухай бүр	-Зарыг цахим хуудсанд баршуулсан байх -Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээсэн байх. - төлөөллийг оролцуулсан байх	Санхүү, Үйлдвэр, Хөрөнгө оруулалтын газар	



20		20.2 Тендерийн үнэлгээний хөрөнгө бүрэлдэхүүнд тухай салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах	Багаар Хүн/өдөр		Тухай бүр	-Зардал хуудсанд баршуулсан байх -Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээсэн байх. - төлөөллийг оролцуулсан байх -Хүний нөөцийг ил тод байдлаар шударгаар бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг алба хаагч нар бүрэлдүүлсэн байх	Санхүү, Үйлдвэр, Хөрөнгө оруулалтын газар		
----	--	--	--------------------	--	-----------	---	---	--	--

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар